МОНГОЛ УЛСЫН
ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ АЖ АХУЙН
ЯАМ

13381 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Энхтайваны өргөн чөлөө 16а, Засгийн газрын IX байр,
Утас: 26-22-71, Факс: (976-11) 45-31-21,
E-mail: mofa@mofa.gov.mn; http://www.mofa.gov.mn

2013.11.13 № 01/4362

танай ____________-ны №____________-т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ЭДИЙН
ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНД

Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд тус яамнаас махны хангамж, нөөцийн талаарх мэдээг хуваарийн дагуу хүргүүлж байна.

Хавсралт 1 хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Х.ЗОЛЖАРГАЛ

2015.11.26.

0000005154

# МАХНЫ ХАНГАМЖ НӨӨЦИЙН ТАЛААРХ МЭДЭЭ

<u>2013 оны нөөцийн махны талаар:</u>

Монголбанкны Ерөнхийлөгч, Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын хамтарсан А-166/А-24 дугаартай тушаалаар батлагдсан "Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах" дэд хөтөлбөрийн хүрээнд Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотын хүн амын 2013 оны хэрэгцээнд зориулан 11,4 мян.тн махны нөөц бэлтгэж, 87.0 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгож, хуваарийн дагуу 100% буцаан төвлөрүүлсэн.

<u>2014 оны нөөцийн махны талаар:</u>

"Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2014 онд Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотын хүн амын хэрэгцээнд махны нөөц бүрдүүлэх, хадгалах, ангилан савлах, худалдаалах үйл ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий "Нөөцийн махны менежер"-ийг 2013 оны 9 сард сонгон шалгаруулж, гэрээ байгуулан ажиллаж эхлээд байна.

Хөтөлбөрийн хүрээнд 2014 онд нийт 14,0 мян.тн махны нөөц бүрдүүлж, худалдан борлуулна. Үүнд:

- Дархан хотын "Нөөцийн махны менежер" болох "Дархан мийт фууд" ХХК нь 1000 тн мах;
- Эрдэнэт хотын "Нөөцийн махны менежер" болох "Эрдмийт" ХХК нь 1000 тн мах;
- УБ хотын "Нөөцийн махны менежер" болох "Эи Эн Ди Эм" ХХК нь 6000 тн мах;
- УБ хотын "Нөөцийн махны менежер"-ээр "Баатарууд тэнгэр" ХХК нь 6000 тн махны нөөц бүрдүүлэн, ангилан савлаж, худалдан борлуулна.

ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ АЖ АХУЙН ЯАМ